



МОНГОЛ УЛС
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2018 оны 05 сарын 02 өдөр

Дугаар А/204

Мандалговь

Зардал гаргах тухай

Монгол улсын Барилгын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2018 оны 03 дугаар сарын 23-ны өдрийн А/118 дугаар захирамжаар батлагдсан "Техник хяналтын зардлыг захиран зарцуулах журам"-ын 3.1.2 дахь заалт, Барилга, хот байгуулалтын сайдын 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 1/1085 дугаар албан тоотыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Тус аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын албан хэрэгцээнд шаардагдах суудлын автомашины үнэ болох 18 сая /арван найман сая/ төгрөгийг техник хяналтын зардлаас гаргахыг аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/-д зөвшөөрсүгэй.

Хоёр. Хяналтын зардлыг баталсан журмын дагуу төлөвлөж, зарцуулалтад хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга /Э.Чагнаадорж/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



О.БАТ-ЭРДЭНЭ

0200595

